



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 241

Улаанбаатар хот

“МИК актив тав” ХХК-д тусгай  
зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МИК актив тав” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус компанийн гаргаж буй орон сууцны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг гүйцэтгэх эцсийн хугацаанаас багагүй хугацаагаар олгосугай.

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны төрөл болон оноосон нэрэнд өөрчлөлт оруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн энэ тухай Санхүүгийн зохицуулах хороонд эргэн мэдэгдэхийг “МИК актив тав” ХХК-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Т.Жамбаажамц/-г тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000824